



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Булган сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: АРА-2025/3/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.open.audit.mn
Архангай аймаг
2025 он

Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа
Утас: 7033-3141
Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn
Аудитын менежер Д.Нэргүйбаатар
Утас: 7033-2860
Цахим хаяг: Nerguibaatar@audit.gov.mn
Ахлах аудитор Г.Цог-Эрдэнэ
Утас: 99210906
Цахим хаяг: Tsogerdeneg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2025.02.20 № 26

танай _____-ны № _____-т

АРХАНГАЙ АЙМГИЙН БУЛГАН СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Н.БАТ-ЭРДЭНЭ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Булган сумын ЗДТГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Архангай аймгийн Булган сумын ЗДТГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн Сангийн Сайдын баталсан журмын дагуу бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

- Албан хаагчдын хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны урамшууллыг зөрүүтэй тооцож, албан татварыг суутгаагүй нийт 5,087.6 мянган төгрөгийг илүү олгосон;
- Сумын ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд худалдан авсан 12,700.0 мянган төгрөгийн эцэг малыг нас, зүсээр бүртгээгүй, оршин байгаа эсэх нь нотлогдохгүй, малчдад ашиглуулсан гэх боловч ашиглалтын гэрээ байгуулаагүй;
- Өвс, тэжээлийг худалдан борлуулж олсон 11,143.000 төгрөгийн орлогыг тус байгууллагын нярвын хувийн харилцах дансаар дамжуулсан бөгөөд төсөвт төвлөрүүлээгүй;

Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.3, 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5.7, 35 дугаар зүйлийн 35.5, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.1.1, 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалтууд, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.1, 13.6, 20.2.4 дэх заалтуудыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх, иж бүрэн байх, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд ойн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөөг 496,282.8 мянган төгрөгөөр давуулан биелүүлж Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18

дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт заасны дагуу **421,840.4** мянган төгрөгийг байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулахаар баталж, гүйцэтгэлээр **301,840.4** мянган төгрөгийг зарцуулан, **120,000.0** мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээний хүрээнд орон нутгийн төсвөөс **1,566,11.2** мянган төгрөгийн санхүүжилт авч, гүйцэтгэлээр 87.1 хувь буюу **1,363,765.3** мянган төгрөгийг зарцуулж, 202,345.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. Төсөвт буцаан төвлөрүүлсэн шилжүүлгийн дийлэнх нь ойн нөөц ашигласны төлбөрийн төлөвлөгөөнөөс давсан орлого байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 үндсэн зорилтын хүрээнд 34 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 30 арга хэмжээг 100 хувь, 3 арга хэмжээг 70 хувь, 1 арга хэмжээг 60 хувь биелүүлж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн Б/13 дугаар захирамжаар 96 хувьтай үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Данс	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	66,469,168.00	93,853,387.00
35	БАРАА МАТЕРИАЛ	66,469,168.00	93,853,387.00
354	Хангамжийн материал	66,469,168.00	81,153,387.00
3542	Аж ахуйн материал	41,599,168.00	43,553,368.00
3547	Бусад хангамжийн материал	24,870,000.00	37,600,019.00
356	Мал амьтад		12,700,000.00
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,315,115,673.53	2,026,124,666.05
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,315,115,673.53	2,026,124,666.05
392	Биет хөрөнгө	1,295,719,673.53	2,006,728,666.05
39201	Барилга, байгууламж, орон сууц	461,774,022.56	461,774,022.56
39202	Хуримтлагдсан элэгдэл	-86,955,814.09	-108,856,058.37
39203	Авто-тээврийн хэрэгсэл	223,860,857.33	340,556,749.33
39204	Хуримтлагдсан элэгдэл	-105,383,370.55	-54,635,107.13
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	204,793,386.00	150,034,001.93
39206	Хуримтлагдсан элэгдэл	-167,749,269.27	-54,645,179.10
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	23,666,230.00	22,846,000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-13,574,859.38	-14,739,779.42
39209	Зам, гүрийн байгууламж	443,192,086.00	246,752,486.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-223,076,199.73	-99,655,868.49
39214	Бусад үндсэн хөрөнгө	712,138,979.00	1,083,555,824.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-419,947,386.34	-209,239,437.26
39216	Дуусаагүй барилга, байгууламж	242,981,012.00	242,981,012.00
393	Биет бус хөрөнгө	19,396,000.00	19,396,000.00
39301	Программ хангамж	4,200,000.00	4,200,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-4,200,000.00	-4,200,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	19,396,000.00	19,396,000.00
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,381,584,841.53	2,119,978,053.05
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,381,584,841.53	2,119,978,053.05
51	Засгийн газрын хувь оролцоо	1,381,584,841.53	2,119,978,053.05
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	320,106,269.20	320,106,269.20
51101	Өмч: - төрийн	320,106,269.20	320,106,269.20
512	Хуримтлагдсан үр дүн	941,091,710.75	1,679,484,922.27
5121	Өмнөх үеийн үр дүн	941,091,710.75	941,091,710.75
5122	Тайлант үеийн үр дүн		738,393,211.52
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	120,386,861.58	120,386,861.58
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,381,584,841.53	2,119,978,053.05

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,520,623,575.33	2,478,095,371.93
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	603,252,521.33	904,437,410.93
120	Нийтлэг татварын бус орлого	603,252,521.33	904,437,410.93
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,405,500.00	2,865,640.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	548,132,021.33	856,917,551.93
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	52,715,000.00	44,654,219.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	917,371,054.00	1,573,657,961.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	15,481,854.00	7,546,761.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		2,050,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	81,600.00	4,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15,400,254.00	1,496,761.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	901,889,200.00	1,566,111,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	901,889,200.00	1,566,111,200.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,088,026,917.59	1,644,502,160.45
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,088,026,917.59	1,644,502,160.45
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	972,958,760.59	1,382,214,520.45
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	399,585,900.00	608,088,000.00
210101	Үндсэн цалин	279,555,503.61	383,136,342.50
210102	Нэмэгдэл	98,240,343.24	199,074,232.50
210104	Урамшуулал	21,790,053.15	25,877,425.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	49,948,200.00	76,011,000.00
210201	Тэтгэврийн даатгал	33,964,700.00	51,687,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,995,900.00	6,080,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,196,700.00	4,864,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	799,200.00	1,216,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,991,700.00	12,161,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35,300,000.00	57,000,000.00
210301	Гэрэл, цахилгаан	8,000,000.00	17,000,000.00
210302	Түлш, халаалт	27,300,000.00	40,000,000.00

Архангай аймгийн Булган сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2104	Хангамж, бараа материалын зардал	63,216,600.00	66,777,000.00
210401	Бичиг хэрэг	6,000,000.00	9,000,000.00
210402	Тээвэр, шатахуун	15,081,600.00	26,050,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,563,600.00	6,000,000.00
210404	Ном, хэвлэл	1,000,000.00	1,900,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	10,665,200.00	12,088,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	23,906,200.00	11,739,000.00
2105	Норматив зардал		1,500,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		1,500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,031,600.00	37,262,800.00
210604	Урсгал засвар	16,031,600.00	37,262,800.00
2107	Томилолт, зочны зардал	5,000,000.00	9,000,000.00
210702	Дотоод албан томилолт	5,000,000.00	9,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	201,151,697.00	225,533,745.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	194,301,697.00	223,133,745.00
210803	Даатгалын үйлчилгээ	150,000.00	100,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	200,000.00	100,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	150,000.00	100,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,250,000.00	2,000,000.00
210807	Газрын төлбөр	100,000.00	100,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	202,724,763.59	301,041,975.45
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	39,401,500.00	91,705,400.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	163,323,263.59	209,336,575.45
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	115,068,157.00	262,287,640.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		58,076,110.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		58,076,110.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	115,068,157.00	204,211,530.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	115,068,157.00	204,211,530.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	432,596,657.74	833,593,211.48
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		95,199,999.96
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		95,199,999.96
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)		-95,199,999.96
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	432,596,657.74	738,393,211.52

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	919,776,554.00	1,576,523,601.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,405,500.00	2,865,640.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,405,500.00	2,865,640.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,405,500.00	2,865,640.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	917,371,054.00	1,573,657,961.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	15,481,854.00	7,546,761.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		2,050,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	81,600.00	4,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15,400,254.00	1,496,761.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	901,889,200.00	1,566,111,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	901,889,200.00	1,566,111,200.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	897,066,554.00	1,417,895,585.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	897,066,554.00	1,417,895,585.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	781,998,397.00	1,155,607,945.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	399,585,900.00	608,088,000.00
210101	Үндсэн цалин	279,555,503.61	383,136,342.50
210102	Нэмэгдэл	98,240,343.24	199,074,232.50
210104	Урамшуулал	21,790,053.15	25,877,425.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	49,948,200.00	76,011,000.00
210201	Тэтгэврийн даатгал	33,964,700.00	51,687,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,995,900.00	6,080,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,196,700.00	4,864,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	799,200.00	1,216,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,991,700.00	12,161,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35,000,000.00	57,000,000.00
210301	Гэрэл, цахилгаан	8,000,000.00	17,000,000.00
210302	Түлш, халаалт	27,000,000.00	40,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	35,606,300.00	66,777,000.00
210401	Бичиг хэрэг	6,000,000.00	9,000,000.00
210402	Тээвэр, шатахуун	10,081,600.00	26,050,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,859,500.00	6,000,000.00
210404	Ном, хэвлэл	1,000,000.00	1,900,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	10,665,200.00	12,088,000.00

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,000,000.00	11,739,000.00
2105	Норматив зардал		1,500,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		1,500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,092,800.00	37,262,800.00
210604	Урсгал засвар	16,092,800.00	37,262,800.00
2107	Томилолт, зочны зардал	5,000,000.00	9,000,000.00
210702	Дотоод албан томилолт	5,000,000.00	9,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	201,451,697.00	225,533,745.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	194,601,697.00	223,133,745.00
210803	Даатгалын үйлчилгээ	150,000.00	100,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	200,000.00	100,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	150,000.00	100,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,250,000.00	2,000,000.00
210807	Газрын төлбөр	100,000.00	100,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	39,313,500.00	74,435,400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	39,313,500.00	74,435,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	115,068,157.00	262,287,640.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		58,076,110.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		58,076,110.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	115,068,157.00	204,211,530.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	115,068,157.00	204,211,530.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	22,710,000.00	158,628,016.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	22,735,000.00	158,628,016.00
	Дотоод эх үүсвэрээр	22,735,000.00	158,628,016.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	22,735,000.00	158,628,016.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-22,735,000.00	-158,628,016.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-25,000.00	0
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		0

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын сан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	ЗГ-н хувь оролцооны дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	320,106,269.20	120,386,861.58	508,495,053.01	948,988,183.79
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
7	Тайлант үеийн үр дүн			432,596,657.74	432,596,657.74
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	320,106,269.20	120,386,861.58	941,091,710.75	1,381,584,841.53
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
17	Тайлант үеийн үр дүн			738,393,211.52	738,393,211.52
19	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	320,106,269.20	120,386,861.58	1,679,484,922.27	2,119,978,053.05

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,567,111,200.00	1,364,765,310.00	202,345,890.00	87.09
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,427,111,200.00	1,302,765,310.00	124,345,890.00	91.29
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,368,689,200.00	1,244,689,200.00	124,000,000.00	90.94
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	608,088,000.00	608,088,000.00	0.00	100.00
210101	Үндсэн цалин	608,088,000.00	383,136,342.50	224,951,657.50	63.01
210102	Нэмэгдэл		199,074,232.50	-199,074,232.50	
210104	Урамшуулал		25,877,425.00	-25,877,425.00	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	76,011,000.00	76,011,000.00	0.00	100.00
210201	Тэтгэврийн даатгал	51,687,400.00	51,687,400.00	0.00	100.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,080,900.00	6,080,900.00	0.00	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,864,700.00	4,864,700.00	0.00	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,216,200.00	1,216,200.00	0.00	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	12,161,800.00	12,161,800.00	0.00	100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	57,000,000.00	57,000,000.00	0.00	100.00
210301	Гэрэл, цахилгаан	17,000,000.00	17,000,000.00	0.00	100.00
210302	Түлш, халаалт	40,000,000.00	40,000,000.00	0.00	100.00

Архангай аймгийн Булган сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2104	Хангамж, бараа материалын зардал	64,727,000.00	64,727,000.00	0.00	100.00
210401	Бичиг хэрэг	9,000,000.00	9,000,000.00	0.00	100.00
210402	Тээвэр, шатахуун	24,000,000.00	24,000,000.00	0.00	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,000,000.00	6,000,000.00	0.00	100.00
210404	Ном, хэвлэл	1,900,000.00	1,900,000.00	0.00	100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	12,088,000.00	12,088,000.00	0.00	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,739,000.00	11,739,000.00	0.00	100.00
2105	Норматив зардал	1,500,000.00	1,500,000.00	0.00	100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,500,000.00	1,500,000.00	0.00	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	41,262,800.00	37,262,800.00	4,000,000.00	90.31
210604	Урсгал засвар	41,262,800.00	37,262,800.00	4,000,000.00	90.31
2107	Томилолт, зочны зардал	9,000,000.00	9,000,000.00	0.00	100.00
210702	Дотоод албан томилолт	9,000,000.00	9,000,000.00	0.00	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	438,640,400.00	318,640,400.00	120,000,000.00	72.64
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	436,240,400.00	316,240,400.00	120,000,000.00	72.49
210803	Даатгалын үйлчилгээ	100,000.00	100,000.00	0.00	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	100,000.00	100,000.00	0.00	100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	100,000.00	100,000.00	0.00	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,000,000.00	2,000,000.00	0.00	100.00
210807	Газрын төлбөр	100,000.00	100,000.00	0.00	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	72,460,000.00	72,460,000.00	0.00	100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	72,460,000.00	72,460,000.00	0.00	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	58,422,000.00	58,076,110.00	345,890.00	99.41
2132	Бусад урсгал шилжүүлэг	58,422,000.00	58,076,110.00	345,890.00	99.41
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	58,422,000.00	58,076,110.00	345,890.00	99.41
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	140,000,000.00	62,000,000.00	78,000,000.00	44.29
	Дотоод эх үүсвэрээр	140,000,000.00	62,000,000.00	78,000,000.00	44.29

220001	Барилга байгууламж	36,000,000.00	18,000,000.00	18,000,000.00	50.00
222001	Тоног төхөөрөмж	31,000,000.00	44,000,000.00	-13,000,000.00	141.94
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,567,111,200.00	1,364,765,310.00	202,345,890.00	87.09
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,566,111,200.00	1,363,765,310.00	202,345,890.00	87.08
132001	Орон нутгийн төсвөөс	1,566,111,200.00	1,363,765,310.00	202,345,890.00	87.08
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,000,000.00	1,000,000.00	0.00	100.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0	0.00	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		0	0.00	
2	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0.00	100.00
3	Төсвийн байгууллага	1	1	0.00	100.00
6	Удирдах ажилтан	3	3	0.00	100.00
7	Гүйцэтгэх ажилтан	18	18	0.00	100.00
8	Үйлчлэх ажилтан	4	4	0.00	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Д/Д	Үзүүлэлт	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	7,546,761.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	7,546,761.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,546,761.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,050,000.00
210402	Тээвэр, шатахуун	2,050,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,521,361.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,521,361.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,975,400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,975,400.00
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	7,546,761.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	7,546,761.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	2,050,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө оруулалтын	1,496,761.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа илрээгүй харин нийт **59,530.6** мянган төгрөгийн зөрчил¹ илэрсэнд 16,230.6 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, 43,300.0 мянган төгрөгийн зөрчилд 5 албан шаардлага хүргүүлсэн.

Аудитаар залруулагдаагүй 7 зөрчилтэй асуудлын материаллаг алдаа зөрчил нь 59,530.6 мянган төгрөг бөгөөд тогтоосон гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн **17,630.0** мянган төгрөгөөс их шинж чанарын хувьд материаллаг байх тул **Хязгаарлалттай дүгнэлт** өглөө.

3.1 Албан шаардлага

3.1.1. 2024 оны сумын ЗДТГ-ын үйл ажиллагаа болон санхүү, төсвийн гүйцэтгэлд дотоод хяналт шалгалтыг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4, МУЗГ-ын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын 4.1.5 дахь заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгуулж, дотоод хяналтыг хэрэгжүүлж, үр дүнг тооцож ажиллах албан шаардлагыг хүргүүллээ.

3.1.2. Булган сумын ЗДТГ нь 2023 онд төсвийн хөрөнгөөр 24,870.0 мянган төгрөгийг өвс тэжээлийн нөөц бэлтгэсэн ба малчдад үнэ төлбөргүй таарсан байна. Мөн 2024 онд төсвийн хөрөнгөөр буюу сумын Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас 2024.11.29-нд өвс тэжээлд 18,700.0 мянга, гамшгаас хамгаалах зардлаас 2024.11.29 нд өвс тэжээлд 11,900.0 мянга, нийт 30,600.0 мянган төгрөгийн өвс, тэжээлийг бэлтгэж нөөц бүрдүүлсэн хэдий ч гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх арга хэмжээг аваагүй байна.

Энэ нь Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.3, Төсвийн тухай хуулийн 5.1.3, Төрийн хэмнэлтийн хуулийн 4.1.3, 15.1.6 дахь заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгуулж, төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн өвс, тэжээлийг үр ашиггүй удаан хадгалахгүй, худалдан борлуулах чиглэлээр арга хэмжээг авч дараа жилийн нөөц бүрдүүлэх эх үүсвэрийг төсөвт төвлөрүүлж ажиллах албан шаардлагыг хүргүүллээ.

3.1.3. Булган сумын 2024 оны сумын ОНХС-ийн хөрөнгөөр бэлтгэсэн 12,700.0 мянган төгрөгийн үнэтэй 33 толгой хуц, ухныг малчин өрхүүдэд хүлээлгэн өгөхдөө төрийн өмчийн ашиглалтыг сайжруулж, үр ашгийг дээшлүүлэх чиглэлээр түрээсийн гэрээ байгуулаагүй байна.

Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгө түрээслүүлэх журам"-ын 1.3-д "Төр өөрийн өмчийн эд хөрөнгийг иргэн, хуулийн этгээдэд түрээсээр эзэмшүүлэх зорилго нь төрийн өмчийн ашиглалтыг сайжруулж, үр ашгийг дээшлүүлэх, төсвийн хөрөнгийг нэмэгдүүлэхэд чиглэгдэнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгуулж, түрээслэгч 33 иргэнтэй төрийн өмчийн 33 толгой хуц, ухны ашиглалтыг сайжруулж, үр ашгийг дээшлүүлэх чиглэлээр түрээсийн гэрээ байгуулж ажиллах албан шаардлагыг хүргүүллээ.

3.1.4. Булган сумын ЗДТГ-ын дарга, нягтлан бодогч нар нь 2024 онд арилжааны банкны дансаар самрын нөөц ашиглуулах дуудлага худалдааны дэчин, баяр наадмын зардал,

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

шагнал нийт 290,758.6 мянган төгрөгийн гүйлгээг дамжуулан хийсэн байна. (Булган сумын ЗДТГ-ын Хаан банкны 5153078545 дансыг 2024.11.20-ны өдөр хаасан байна)

Энэ нь Төсвийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2-д "Төсвийн байгууллага нь төвлөрүүлсэн төсвийн орлого болон өөрийн үйл ажиллагааны орлогыг Төрийн сангийн нэгдсэн дансанд саадгүй байршуулна", 35.3-д "Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр банкинд тусдаа данс нээснээс бусад тохиолдолд төсөвт хамаарах бүх гүйлгээг Төрийн сангийн нэгдсэн дансаар гүйцэтгэнэ", МУЗГ-ын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 444 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 3.5.6-д "Дараах зөрчил илэрсэн тохиолдолд зөрчлийг арилгах хүртэлх хугацаанд зарлагын гүйлгээг түр зогсооно", 3.5.6.1-д "зөвшөөрөлгүйгээр банканд данс нээсэн" гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Булган сумын ЗДТГ-ын дарга, нягтлан бодогч нарт хуульд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагыг сумын Засаг даргад хүргүүлээ.

3.1.5. Тайлант онд Булган сумын Засаг дарга нь 2 иргэнтэй гэрээ байгуулан өвс, тэжээл худалдан авч, сумын ЗДТГ-ын нярвын харилцах дансаар 26,018.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно" гэж заасны дагуу Сумын Засаг даргад сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлээ.

3.2 Төлбөрийн акт

3.2.1. Булган сумын Засаг даргын 2024.02.01-ны өдрийн Б/05 дугаар захирамжаар сумын Санхүүгийн албаны дарга Г.Отгонцэцэгт 7,920.0 мянга, 2024.05.15-ны өдрийн Б/04 дугаар захирамжаар сумын ЗДТГ-ын дарга Н.Бат-Эрдэнэд 9,466.3 мянга, сумын ЗДТГ-ын даргын 2024.05.15-ны өдрийн Б/13 дугаар тушаалаар Төрийн сангийн мэргэжилтэн Б.Батсүхэд 7,146.7 мянга, хууль эрхзүй хариуцсан мэргэжилтэн Г.Дэлгэрцэцэгт 6,555.7 мянга, Хүнс хөдөө аж ахуйн мэргэжилтэн Д.Батболдод 6,555.7 мянга, Байгаль орчны мэргэжилтэн Б.Батдоржид 7,320.0 мянга, Ойн хамгаалагч Х.Мэндбаярт 6,555.7 мянга, С.Цолмонд 6,555.7 мянга нийт 58,076.1 мянган төгрөгийн тогтвор суурьшилтай ажилласны 6 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний урамшууллыг тооцож олгохдоо хувь хүний орлогын албан татварыг суутгаагүй байна.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3-т "Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого", 7 дугаар зүйлийн 7.1-д "Албан татвар төлөгчийн цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод дараах орлогыг хамруулна, 7.1.1-д "Ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу авч байгаа үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого" , 21 дүгээр зүйлийн 21.1-д "Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасны дагуу тухайн жилийн орлогыг тодорхойлоход 0-120 000 000 хүртэлх төгрөгийн албан татвар ногдуулах орлого олсон тохиолдолд 10 хувиар ... албан татвар ногдуулна" гэсэн заалтуудтай нийцэхгүй зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Аймгийн төсвийн орлогын 1001000955 данс руу суутган төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

3.2.2. Булган сумын ЗДТГ-ын бараа материалын дансанд бүртгэлтэй өвс, тэжээл нөөцийн 2024 оны орлого, зарлагыг шалгахад өвс, тэжээлийг худалдан борлуулж олсон 11,143.000 төгрөгийн орлогыг тус байгууллагын нярвын хувийн харилцах дансаар дамжуулсан бөгөөд төсөвт төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.3.4-д "төсвийн жилийн явцад шинээр бий болсон аливаа орлого, эх үүсвэр, зээл, хандив, тусламж, тэдгээрээр санхүүжүүлсэн үйл ажиллагааны зарлага нь төсвийн бүрэлдэхүүн байх", 16.5.7-д "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", 35.5-д "Банканд төрийн сангийн нэгдсэн данснаас гадуур нээсэн төсвийн байгууллагын дансанд тухайн шатны төрийн сан болон төрийн аудитын байгууллага үзлэг, хяналт хийн, энэ хуулийн 35.3-т заасан зөвшөөрөлгүйгээр нээсэн дансыг хаалгах, хөрөнгийг төрийн сангийн нэгдсэн дансанд татан төвлөрүүлнэ" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хавсралтад дурдсан 4 албан хаагчдаас 11,143.000 төгрөгийг гаргуулан аймгийн төрийн сангийн 100010000955 Ар.Бусад нэр заагдаагүй орлого дансанд төвлөрүүлэхээр акт тогтоов.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
санхүү, төсвийн гүйцэтгэлд дотоод хяналт шалгалтыг хэрэгжүүлээгүй	1	-			1	-						
төрийн өмчийн ашиглалтыг сайжруулж, үр ашгийг дээшлүүлэх чиглэлээр түрээсийн гэрээ байгуулаагүй	1	12,500.0			1	12,500.0						
58,076.1 мянган төгрөгийн тогтвор суурьшилтай ажилласны 6 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмжийг тооцож олгохдоо хувь хүний орлогын албан татварыг суутгаагүй	1	5,087.6	1	5,087.6								
30,600.0 мянган төгрөгийн өвс, тэжээлийг бэлтгэж нөөц бүрдүүлсэн хэдий ч гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх арга хэмжээг аваагүй	1	30,600.0			1	30,600.0						
Өвс тэжээлийн орлогыг төсөвт төвлөрүүлээгүй	1	11,143.0	1	11,143.0								
Сахилгын шийтгэл ногдуулах	1								1			
Сахилгын шийтгэл ногдуулах	1								1			
Дүн	7	48,387.6	2	16,230.6	3	43,100.0			2			